



ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 3-р сарын 27-оос
4-р сарын 2-ны байдлаар

ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 3-р сарын 27-оос 4-р сарын 2-ны байдлаар

COVID-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, Пандемик (цар тахал)-ын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулах зорилгоор улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанк долоо хоног тутмын гадаад орчны тойм мэдээллийг хүргэж байна. Тус тоймыг гурав дахь дугаарыг хүргэж байгааг хүлээн авна уу.

1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч агентлагууд, санхүүгийн байгууллагуудын дэлхийн эдийн засгийн өсөлтийн талаар өнгөрсөн 7 хоногт шинэчлэн гаргасан төсөөллийг Хүснэгт 1-т харуулав.

Хүснэгт 1. Санхүүгийн байгууллага, олон улсын байгууллагуудын дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл

	Эх сурвалж	2020 он				
		Төсөөлөл гаргасан огноо	Дэлхийн эдийн засгийн өсөлт	Хятадын өсөлт	АНУ-ын өсөлт	Евро бүсийн өсөлт
1.	S&P	3/31/2020	0.4%	3.0%	-1.3%	-2.0%
2.	Fitch	3/31/2020		2.6%	-1.0%	
3.	Moody's	3/27/2020	-0.5%	3.3%	-2.0%	-2.2%
4.	Дэлхийн банк	3/31/2020		2.3%		

Эх сурвалж: Төсөөлөл хийсэн байгууллагуудын цахим хуудаснууд

- Focus Economics агентлагаас 7 хоног бүр “COVID-19 цар тахлын дэлхийн эдийн засагт үзүүлэх нөлөө” түүвэр судалгааг олон улсын шинжээчдийн дунд явуулж байна. 4-р сарын 1-ний өдөр зарласан түүвэр судалгааны үр дүнгээр шинжээчдийн 40 орчим хувь нь COVID-19-ийн дэлхийн эдийн засгийн өсөлтөд үзүүлэх сөрөг нөлөө 3 нэгж хувиас өндөр, 68 хувь нь COVID-19-ийн дэлхийн эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөө 2021 онд үргэлжилнэ¹, 58 хувь нь дэлхийн эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөө U хэлбэртэй байна гэж үзэж байна.
- McKinsey & Co зөвлөх үйлчилгээний фирмээс 3-р сарын 25-ны өдөр COVID-19-ийн дэлхийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийн хувилбар тооцооллыг шинэчлэн гаргалаа². Уг тооцооллоор тус вирусийн тархалт оны сүүлийн хагаст хяналтад орж, БНХАУ, АНУ-ын эдийн засгууд 2020 оны сүүлээр, Евро бүс 2021 оны эхний улиралд хямралын өмнөх үеийн түвшинд хүрэх тохиолдолд дэлхийн эдийн засгийн өсөлт 2020 онд суурь төсөөллөөс 1.5 нэгж хувиар буурахаар байна. Улмаар БНХАУ-ын өсөлт COVID-19-ийн сөрөг нөлөөгөөр 0.4, АНУ-ынх 0.4, Евро бүсийн нийт

¹ Өмнөх 7 хоногийн түүвэр судалгаагаар 56 хувь байсан.


² McKinsey & Co: [Global health and crisis response](#)

өсөлт 4.4 нэгж хувиар тус тус буурахаар тооцжээ. Харин гутранги хувилбар буюу вирусийн хяналтад орох хугацаа хойшилж, дэлхийн эдийн засаг 2022 оны 3-р улирлаас хямралын өмнөх хэвийн түвшинд ирэх тохиолдолд дэлхийн эдийн засгийн өсөлтөд -4.7 нэгж хувиар сөрөг нөлөө үзүүлэхээр байна.


- PwC компани 2 долоо хоногт 1 удаа глобал компаниудын санхүү эрхэлсэн захирлуудаас коронавирусийн бизнест үзүүлж буй нөлөөллийн талаарх түүвэр судалгаа авч байгаа бөгөөд 3-р сарын 9-нд авсан эхний судалгаагаар компаниудын 90% нь вирус ирэх 1 улирлын дотор бизнесийн үйл ажиллагаа хэвийн түвшинд орох боломжтой гэж хариулжээ. Түүнчлэн, компаниудын 30% нь ханган нийлүүлэлтийн сүлжээгээ өөрчлөх бодолгүй байна гэж хариулж байжээ. Вирусийн тархалт Америк, Европт хурдацтай тархаж эхэлсний дараах судалгааны үр дүн хараахан гараагүй байна.

- "Их 20"-ийн удирдагчид 3-р сарын 26-ны өдөр дэлхийн эдийн засгийн төлөв, COVID-19 цар тахлын нөлөөллийн асуудлаар цахим хурал хийв. Уг хуралд ОУВС-ийн тэргүүн К.Георгиева дэлхийн эдийн засаг сөрөг өсөлттэй гарах төлөвтэйг онцлов. "Их 20"-ийн орнууд COVID-19 цар тахлын ажлын байр, орлогод үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахын тулд төсөв, мөнгөний бодлогоор дэлхийн эдийн засагт нийт 5 их наяд ам.доллар нийлүүлэхээр болов. Мөн эрүүл мэндийн салбарт шаардлагатай бараа, бүтээгдэхүүнийг хангах, тэдгээрийн үнийг зохистой түвшинд барихын тулд үйлдвэрлэлээ нэмэгдүүлж, хөрөнгө оруулалт хийхээ "Их-20"-ийн удирдагчид амлажээ.
- COVID-19 цар тахлын нөлөөгөөр Азийн хөгжиж буй улс орнуудын эдийн засаг 2020 онд дор хаяж 4 нэгж хувиар бууран, Азийн эдийн засаг хямралын төлөвт шилжиж, ойролцоогоор 11 сая хүн ядуурлын эгнээнд шилжих тооцоог Дэлхийн банкнаас 4-р сарын 1-нд гаргав (Зураг 1 болон Зураг 2).

Зураг 1. Дэлхийн банк Азийн орнуудын өсөлтийн төсөөллийг бууруулав.



Зураг 2. COVID-19 нөлөөгөөр Ази, Номхон далайн бүсийн ядуурлын түвшин нэмэгдэж болзошгүй.



Эх сурвалж: Дэлхийн банк

- 1.3 тэрбум хүнтэй Энэтхэг улс 3-р сарын 24-өөс эхлэн бүх нийтийн хөл хорио тогтоосноор олон улсын байгууллагууд тус улсын эдийн засгийн өсөлтийн

төсөөллийг 5.0 гаруй хувиас 2.5-3.5 хувь³ болгон бууруулсан нь дэлхийн эдийн засгийн өсөлтийг сааруулах нөлөө үзүүлэхээр байна.

³ Moody's болон S&P агентлагуудын 2020 оны 3-р сарын 31-ны байдлаар шинэчилсэн төсөөлөл.

- COVID-19 цар тахлын нөлөөгөөр дэлхийн эдийн засгийн өсөлт удааширч, түүхий эдийн эрэлт буурах, **түүхий эдийн үнэ буурах төлөвтэй боллоо**.
- 3-р сард хөгжиж буй орнуудын хөрөнгийн захаас \$83 тэрбум буюу түүхэнд байгаагүй их хэмжээний хөрөнгийн гадагшлах урсгал ажиглагдав. Үүнээс \$52 тэрбум нь хувьцаа, \$31

тэрбум нь бондын захаас гадагшилсан мөнгө байв.

- Ам.долларын индекс 3-р сард $\pm 5\%$ -ийн хэлбэлзэлтэй байсан бол хөгжиж буй орнуудын валют өндөр савлагаатай байв. Өмнөд Африк, Мексик зэрэг орнуудын үндэсний мөнгөн тэмдэгт ам.долларын эсрэг 1 өдөрт 2%-аар суларч байна.

2 ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- Хятадын эдийн засаг** энэ оны 2-р сарын эцэст потенциал түвшний 60-70 хувиар ажиллаж байсан бол 3-р сарын 27-ны байдлаар **90 хувьд хүрч эхэллээ**⁴. Нийт жижиг аж ахуй нэгж, компаниудын 71.7 хувь нь 3-р сарын 24-ны байдлаар ажилдаа эргэн ороод байна⁵. Хубей мужаас бусад бүс нутгуудын голлох барилгын төслүүдийн 89 хувь нь 3-р сарын 20-оос хойш эргээд бүрэн хүчин чадлаараа ажиллаж байна⁶. Хятадын хамгийн том ган үйлдвэрлэлийн төв Тяньшан дахь гангийн үйлдвэрүүд сүүлийн 3 долоо хоногийн турш 72-73 хувийн хүчин чадлаараа буюу Цагаан сарын өмнөх түвшинд ажиллав. Иймд барилгын салбарын идэвхжил алгуур сэргэх хүлээлттэй байна.
- Хятадын аж үйлдвэрийн PMI индекс 3-р сард хүлээлтээс давж 52 хүрч, аж үйлдвэрлэлийн идэвхжил алгуур сэргэж байгаа ч, хэвийн түвшинд хүрэх болоогүй байна.** Тус индекс 2-р сард 35 буюу түүхэн доод түвшинд хүрч буурсан бол 3-р сард сэргэж байгаа нь дотоодын аж үйлдвэрлэгчдэд эерэг

дохио өгч байна. Индексийн бүлгүүдээр задалж харвал үйлдвэрлэлийн индекс 2-р сард 27.8 байсан бол 3-р сард 54.1, бизнесийн хүлээлтийн индекс 41.8-аас 54.4 хүрээд байна. Харин аж үйлдвэрлэлийн бус индексийн шинэ захиалгын бүлэг бууралттай хэвээр байгаа нь үйлчилгээний эрэлт төдийлөн нэмэгдээгүйг илтгэж байна. Түүнчлэн Шанхайн Шензен CSI 300 индексийн үл хөдлөх хөрөнгийн индекс нь өмнөх сараас 8 хувиар буурсан нь дотоод эрэлт сул, үл хөдлөх хөрөнгийн салбар төдийлөн сэргээгүйг илтгэж байна.

- COVID-19 цар тахлаас шалтгаалан коксжих нүүрсний дэлхийн зах зээл дээрх үнэ болон Хятадын эрчим хүчний нүүрсний үнэ оны сүүлийн хагас руу буурах төлөвтэй байна. Харин Хятадын Засгийн газраас хэрэгжүүлэх дэд бүтцийн шинэ төслүүдийн⁷ нөлөөгөөр гангийн үйлдвэрлэл өндөр хэвээр хадгалагдах тул **Хятадын дотоодын коксжих нүүрсний үнэ харьцангуй тогтвортой байх төлөвтэй** байгааг SXCoal 4-р сарын 1-нд мэдээлэв⁸.

⁴ Блүмбергийн шинжээчдийн тооцоолол. Үүнд тооцоололд вирусийн голомт Хубэй муж ороогүй болно.

⁵ Хятадын Хөгжил, шинэтгэлийн хорооноос энэ оны 3-р сарын 29-ний өдөр хийсэн мэдэгдэл.

⁶ Хятадын Аж үйлдвэр, мэдээлэл технологийн яамнаас энэ оны 3-р сарын 24-ний өдөр хийсэн мэдэгдэл

⁷ Уг дэд бүтцийн төсөлд 5G суурь станц байгуулах, UHV дамжуулах шугам барих, өндөр хурдны болон хот доторх галт тэрэг, авто замын төслүүд, Big Data, AI болон аж үйлдвэрийн интернет хөгжүүлэх төслүүд багтжээ.

⁸ SXcoal: [Coal and Downstream Markets Outlook Under the COVID-19 Global Pandemic](#)

Түүнчлэн, өнгөрсөн 7 хоногт зарлагдсан Шанши группийн коксжих нүүрсний гэрээний үнэ тогтвортой байна. Хятадын төмрийн хүдэр болон гангийн үйлдвэрийн холбооны 3-р сарын 31-ний мэдээллээр Хятадын голлох үйлдвэрүүд дэх ган үйлдвэрлэлийн дундаж хэмжээ 25 сая тонн хүрч өмнөх сараас 1 хувиар, өмнөх оны мөн үеэс 2.5 хувиар нэмэгдээд байна. Энэ оны 2-р улирлаас гангийн төслүүд эхэлснээр, гангийн эрэлт нэмэгдэж жилийн үйлдвэрлэл өмнөх оны түвшинд байх хүлээлттэй байна. Хятадын ган үйлдвэрлэлийн идэвхжлийг илэрхийлэх PMI индекс 2-р сард 36.6-аас 3-р сард 42.2 хүрч нэмэгдлээ.

- **Хятадын төсвийн бодлого:** Хятадын Төрийн зөвлөлийн 3-р сарын 27-ны хурлаар Засгийн газрын тусгай зориулалттай бонд гаргалтыг нэмэгдүүлж, нийт хөрөнгө оруулалтын өсөлтийг дэмжих, автомашин худалдан авалтыг татвараас чөлөөлөх, жижиг, дунд үйлдвэрлэгч, компаниудад санхүүгийн дэмжлэг олгох хүрээнд 1 их наяд юанийн хөнгөлөлттэй зээл олгох, нийгмийн хамгийн эмзэг давхаргад 6-р

сарыг хүртэл хугацаанд дэмжлэг үзүүлэх гэсэн бодлогын тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойллоо.

- **Хятадын мөнгөний бодлого:** Хятад улсын Төрийн зөвлөлийн 3-р сарын 25, 27-ний хурлуудад “Хятад Улс эдийн засгийн дотоод эрэлтийг дэмжих, энэ жилийн хөгжлийн зорилгоо биелүүлэхийн төлөө хичээх болно” гэж мэдэгдсэн нь эрх баригчид эдийн засагт үүсээд буй сөрөг нөлөөг саармагжуулах бодлогын арга хэмжээг илүү эрчимтэй авч хэрэгжүүлэх хүлээлтийг зах зээлд үүсгээд байна. Хятадын Ардын Банк (ХАБ) 3-р сарын 30-ний өдөр буцах нөхцөлтэй репо санхүүжилтийн хүүг 0.2 нэгж хувиар бууруулж 2.2 хувьд хүргэн, зах зээлд 50 тэрбум юанийг нийлүүлсэн нь 4-р сард бодлогын хүү 0.4 нэгж хувиас илүүгээр буурах хүлээлтийг бий болголоо⁹. Цаашид зээлийн хүүг бууруулах, жижиг дунд бизнесүүдэд олгох зээлийн нөхцөлийг хөнгөрүүлж, дэмжих зэрэг арга хэмжээг авах хүлээлттэй байна. ХАБ энэ онд Заавал байлгах нөөцийн хувийг 1.50-2.0 нэгж хувиар бууруулах хүлээлт мөн хэвээр байна.

3 ГЛОБАЛ ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД, БОДЛОГЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

Улс орнууд COVID-19 цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг үр дагаврыг бууруулахад чиглэсэн төсөв, мөнгөний арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлж байна.

Хөгжингүй орнуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ:

Хүснэгт 2. Хөгжингүй орнуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээний хураангуй

Хэрэгжүүлж буй арга хэмжээ:	Улс
Компаниудад ЗГ-ын зээл, зээлийн баталгаа олгох	Герман, Франц, Итали, Англи, Испани, Америк
Орлогогүй болсон иргэдэд нэмэлт орлого олгох	Герман, Франц, Итали, Испани, Америк
Нийгмийн даатгалын шимтгэлийг түр хугацаанд тэглэх	Герман, Франц, Испани, Англи
Өрийн эргэн төлөлтийг түр царцаах	Итали, Англи, Испани,
Татварыг түр зогсоох	Герман, Франц, Испани, Англи

Эх сурвалж: *Financial times*¹⁰

⁹ Bloomberg: [China Rejoins Monetary Easing Wave as World Shuts Down](#)

¹⁰ FT: [How major economies are trying to mitigate the coronavirus shock](#)

- Японы Засгийн газар 57 их наяд иен (528 тэрбум ам.доллар)-тэй тэнцэх хэмжээний түүхэн дэх хамгийн том дүнтэй эдийн засгийг дэмжих багц арга хэмжээний төслийг 4-р сарын эхээр өргөн барихаар төлөвлөж байна. Уг арга хэмжээнд жижиг, дунд бизнест хүүгүй зээл олгох, иргэд, ААН-д мөнгөн тэтгэмж олгох зэрэг багтжээ.
- Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ) бага, дунд орлоготой өрхүүдэд (4 ам бүлтэй өрхөд 1 сая вон буюу 815 ам.доллар) дэмжлэг үзүүлэх 7.1 их наяд вонын санхүүжилтийн багцыг баталлаа.
- Скандиновын орнууд иргэддээ цалингийнх нь 75-90 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг 3 сарын хугацаанд улсын төсвөөс олгохоор хэлэлцэж байна.
- Сингапурын төв банк ханшийн интервалын голч дунджийн түвшинг бууруулж, налалтыг 0 хүртэл багасгах шийдвэр гаргалаа¹¹. Ингэснээр сингапур долларын ханш суларч, экспортын өсөлтийг дэмжих, дефляциас урьдчилан сэргийлэх юм.

- Австралийн Засгийн газар ирэх 6 сарын хугацаанд ажлын байрыг хамгаалахад зориулан 80 тэрбум ам.доллар зарцуулахаа мэдэгдсэн.

Хөгжиж буй орнуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ:

Хөгжиж буй орнуудын хувьд хөгжингүй орнуудтай харьцуулахад төсөв, мөнгөний тэлэх бодлого хэрэгжүүлэх орон зай хязгаарлагдмал юм. Польш, Колумби, Филиппин, Өмнөд Африк зэрэг орнуудын төв банкууд хоёрдогч зах зээл дээрх засгийн газрын болон хувийн секторын бонд худалдан авалтаа нэмэгдүүлж байна. Бразил болон Чехийн төв банк хоёрдогч зах зээл дээрх засгийн газрын бондыг худалдан авах эрхгүй байдаг тул хуульдаа шинэчлэл оруулахаар ажиллаж байна. Бразил 3-р сарын 27-ны өдөр 233 тэрбум ам.долларын дүнтэй эдийн засгийг дэмжих багц арга хэмжээг хэрэгжүүлэхээ зарласан нь хөгжингүй орнууд дунд хамгийн өндөр дүнтэй санхүүжилтийн багц болоод байна¹².

4 МОНГОЛБАНК, ЗАСГИЙН ГАЗРААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ АРГА ХЭМЖЭЭ

2020 оны 3-р сарын 11-ний өдөр Мөнгөний бодлогын хорооноос санхүүгийн зуучлалыг дэмжих, банкуудын санхүүжилтийн эх үүсвэрийн өртгийг бууруулах, эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх зорилгоор (1) бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулах, (2) төгрөгийн заавал байлгах нөөцийн хувийг 2 нэгж хувиар бууруулж, 324 тэрбум төгрөгийн эх үүсвэр чөлөөлөх, (3) бодлогын хүүний коридорыг бодлогын хүүнээс +/-1 нэгж

хувиар шинэчлэн тогтоох багц шийдвэр гаргасан.

Харин 3-р сарын 18-ны өдөр банкны “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам” болон “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д түр хугацааны өөрчлөлт орууллаа. Ингэснээр иргэнд олгосон зээлд тогтоох хугацааны ангиллыг “Хэвийн” зээлийн хувьд 15 хүртэлх хоног байсныг 90

¹¹ Bloomberg: [Singapore's Central Bank Takes Unprecedented Easing Action](#)

¹² FT: [Emerging market central banks embark on radical stimulus policies](#)

хүртэлх хоног болгож уртасгаж, хэрэглээний болон бизнесийн зээлийн гэрээнд бүтцийн өөрчлөлт хийхэд ангиллыг бууруулахгүй боломжийг бий болголоо.

Түүнчлэн, 3-р сарын 20-ны өдөр банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжихэд чиглэсэн арга хэмжээ авч Төв банкнаас арилжааны банкуудад олгох барьцаат зээлийн журамд өөрчлөлт оруулав. Ингэснээр банкууд барьцааны нөхцөл, шаардлагыг хангаснаар Монголбанкнаас 6 сарын хугацаатай (дахин 6 сараар сунгагдах боломжтой) эх үүсвэрийг 11 хувийн хүүтэй авч, төлбөр түргэн гүйцэтгэх чадвараа хангах боломжийг бүрдүүлэв.

4-р сарын 1-ний өдрөөс эхлэн COVID-19 вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор Монголбанк санаачлан гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд арилжааны банк хоорондын бага дүнтэй гүйлгээний шимтгэлийг дийлэнх банкинд 20%, цөөн банк 100% болгож бууруулахаар боллоо.

Төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй хүүтэй зээл авсан иргэдийг хамруулах зорилгоор Монголбанк, Сангийн яам, Монголын Ипотекийн Корпораци ОССК ХХК болон банкууд хамтран дараах шийдвэрийг гаргалаа. Үүнд:

- Орон сууцны ипотекийн 8 эсхүл 5 хувийн хүүтэй зээл авсан иргэн зээлийн эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулах хүсэлт гаргасан тохиолдолд

зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг нэг удаа 3 хүртэлх сараар хойшлуулж, тухайн хугацаагаар зээлийн эргэн төлөлтийн хуваарийг уртасгах;

- Зээлийн эргэн төлөлтөд нь 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдрөөс хойш доголдол үүссэн зээлдэгчид энэхүү зохицуулалт үйлчлэх боломжтой бөгөөд доголдол үүссэн хуваарьт өдрөөс эхлэн эргэн төлөлтийг хойшлуулах хугацааг тооцох;
- Зээлдэгч зээлийн эргэн төлөлтөд өөрчлөлт оруулах хүсэлтээ 2020 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө харилцагч банкиндаа гаргана.

Эдгээр Монголбанкнаас хэрэгжүүлж буй мөнгөний бодлогын төлөвийг зөөлрүүлэх, банкны зохицуулалтыг түр хугацаанд зөөлрүүлэх, банкны төлбөрийн чадварыг дэмжихэд чиглэсэн бодлогын багц арга хэмжээ нь санхүүгийн зуучлал хэвийн үргэлжлэх боломжийг бүрдүүлээд зогсохгүй COVID-19 цар тахлаас үүдэлтэй эдийн засагт учрах сөрөг нөлөөг бууруулахад чухал нөлөөтэй.

Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх 3-р сарын 27-ны өдөр хийсэн мэдэгдэлдээ Засгийн газрын ээлжит бус хуралдаанаар эдийн засгийн хүндрэлийг даван туулахад чиглэсэн багц арга хэмжээг авч хэрэгжүүлэх болсныг зарласан. Гэхдээ тус багц арга хэмжээний бүлэг тус бүрт ямар хэмжээний эх үүсвэр тусгагдаж байгаа, ямар хүрээнд хэрэгжих зэрэг нь тодорхой бус хэвээр байна.

Монголбанкнаас

Ковид-19 цар тахлын үед авч хэрэгжүүлж буй арга хэмжээ



<p>2020.04.03 Төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны ипотекийн зээлийн эргэн төлөлтийг түр хойшлуулав</p>		<p>Зээлийн эргэн төлөлтөд нь 2020.01.31-ний өдрөөс хойш доголдол үүссэн 8% болон 5%-ийн ипотекийн зээлтэй иргэдийн зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг нэг удаа 3 хүртэлх сараар хойшлуулж, тухайн хугацаагаар зээлийн эргэн төлөлтийн хуваарийг уртасгах боломжийг нээлээ.</p>
<p>2020.04.01 Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний шимтгэлийг бууруулав</p>		<p>2020.04.01-ний өдрөөс эхлэн гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд банк хоорондын бага дүнтэй гүйлгээний шимтгэлийг 20%-100% буурууллаа. Энэхүү шийдвэр нь иргэдийг цахимаар төлбөр тооцоогоо хийхийг дэмжих зорилготой.</p>
<p>2020.03.25 Төв банкнаас банкинд олгох барьцаат зээлийн журамд түр өөрчлөлт оруулав</p>		<p>Банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор банкинд олгох барьцаат зээлийн журамд 2020.07.31-ний өдөр хүртэл түр хугацааны өөрчлөлт орууллаа. Ингэснээр Төв банкнаас банкинд олгох барьцаат зээлийн хугацааг 180 хоног болгон уртасгаж, хүүг 11%-д бууруулав.</p>
<p>2020.03.18 Зээлийн ангилал, эргэн төлөлтөд түр хугацааны өөрчлөлт оруулах боломжийг бүрдүүлэв</p>		<p>Хэрэглээний зээл хэлбэрээр иргэнд олгосон зээлд тогтоох хугацааны ангиллыг "Хэвийн" зээлийн хувьд 90 хүртэлх хоног болгон өөрчилж, зээлийн бүтцийг өөрчлөх буюу холбогдох зээлийн гэрээний нөхцөл, хуваарьт өөрчлөлт оруулах боломжийг банкуудад олгов.</p>
<p>2020.03.11 Төгрөгийн заавал байлгах нөөц (ЗБН)-ийг 2 нэгж хувиар бууруулав</p>		<p>Банкууд төвлөрүүлсэн хадгаламжийнхаа тодорхой хувийг Төв банканд болзошгүй эрсдэлээс сэргийлэхийн тулд байршуулдаг. Төгрөгийн ЗБН-ийг бууруулснаар банкуудад 324 тэрбум төгрөгийн эх үүсвэр чөлөөлөгдөж, зээл хэлбэрээр гарах боломж нэмэгдэх бөгөөд төгрөгийн хадгаламж татах сонирхол нэмэгдэж, долларжилт буурахад нөлөөлнө.</p>
<p>2020.03.11 Хүүгийн коридор системийг шинэчилж, +/- 1 нэгж хувиар тогтоов</p>		<p>Энэхүү шийдвэр нь банк хоорондын захын хүүгийн хэлбэлзлийг бууруулах замаар бодлогын хүүний нөлөөг нэмэгдүүлэх, банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангахад дэмжлэг үзүүлэх нөлөөтэй.</p>
<p>2020.03.11 Бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж 10 хувь болгов</p>		<p>Эдийн засгийн өсөлт саарах хандлага үргэлжилж, инфляци тогтвортой байх төлөвтэй байгаа тул бодлогын хүү 11% байсныг 1 нэгж хувиар буурууллаа. Энэ нь санхүүгийн зуучлалыг хэвийн үргэлжлүүлэх, эдийн засгийн идэвхилийг дэмжихэд эергээр нөлөөлнө.</p>